

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**МӨСТ СУМЫН СУМ ДУНДЫН ЭМНЭЛГИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/2/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Ховд хот
2021 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn

Гэрээт аудитор: Б.Бадамцэцэг

Утас: 70432545

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>

Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	6
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	6
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	10
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	10
2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН	10
3.АУДИТЫН ТАЙЛАН	12
3.1. Ерөнхий зүйл	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	Error! Bookmark not defined.
3.7. Шилэн дансны мэдээлэл	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Залруулсан алдаа	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
3.0. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	16
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	17
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	19

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
64000 Цамбагараа баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

МӨСТ СУМЫН СУМ ДУНДЫН ЭМНЭЛГИЙН
ЭРХЛЭГЧ ЭМЧ Ж.ПҮРЭВБААТАР ТАНАА

2021.03.22 № 4/41
тантай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөст сумын сум дундын эмнэлгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Мөст сумын сум дундын эмнэлгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, эрүүл мэндийн тусламж үйчилгээний чанар үр дүн, эмч эмнэлгийн ажилтны ёс зүйн байдал зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Өмнөх санхүүгийн тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зарим зардлыг зориулалт бусаар зарцуулсан, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, үр дүнгийн урамшууллыг ажлын үр дүнтэй уялдуулан дүгнээгүй, зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн, санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй зэрэг зөрчлүүд "эрх ба үүрэг", "үнэн зөв байдал", "оршин байх", "толилуулга ба тодруулга", "тохиолдсон байх", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын

021020674

стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>71,480,910.55</u>	<u>92,316,952.24</u>
33	АВЛАГА	606,600.00	6,339,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	606,600.00	606,600.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	5,732,400.00
35	БАРАА МАТЕРИАЛ	70,874,310.55	85,977,952.24
351	Түүхий эд материал	26,379,337.35	42,367,129.04
35130	Эм боох материал	26,379,337.35	42,367,129.04
354	Хангамжийн материал	44,494,973.20	43,610,823.20
35410	Бичиг хэргийн материал	643,250.00	28,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,144,000.00	2,688,000.00
35440	Түлш, шатах тослох материал	651,900.00	2,350,000.00
35460	Хүнсний материал	2,306,000.20	300,000.20
35470	Бусад хангамжийн материал	37,749,823.00	38,244,823.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>553,288,852.19</u>	<u>580,798,655.93</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	553,288,852.19	580,798,655.93
392	Биет хөрөнгө	542,720,852.33	570,318,656.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	490,354,000.00	490,354,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-18,467,146.76	-26,325,720.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	108,132,000.00	132,052,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-78,833,611.32	-71,423,444.70
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	171,642,807.10	135,670,257.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	-141,952,553.68	-105,385,564.30
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,513,406.00	43,513,406.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26,668,049.01	-28,136,277.81
393	Биет бус хөрөнгө	10,567,999.86	10,479,999.84
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-616,000.14	-704,000.16
39303	Бусад биет бус хөрөнгө	10,304,000.00	10,304,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>624,769,762.74</u>	<u>673,115,608.17</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>11,498,298.14</u>	<u>14,463,424.29</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,498,298.14	14,463,424.29
413	Өглөг	11,498,298.14	14,463,424.29
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	6,844,482.00	4,874,072.37
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,997,714.14	8,279,157.14
4136	Бусад өглөг	1,656,102.00	1,310,194.77
41361	Байгууллагад төлөх өглөг	1,656,102.00	1,240,852.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	69,342.77
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>613,271,464.60</u>	<u>658,652,183.88</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	613,271,464.60	658,652,183.88

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	176,837,308.00	176,837,308.00
51101	Өмч: - төрийн	176,837,308.00	176,837,308.00
512	Хуримтлагдсан үр дүн	15,735,061.52	66,866,500.80
51210	Өмнөх үеийн үр дүн	15,735,061.52	21,485,781.52
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	45,380,719.28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	420,699,095.08	414,948,375.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	624,769,762.74	673,115,608.17

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	474,960,246.00	601,722,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,481,100.00	37,900,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,481,100.00	37,900,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,481,100.00	37,900,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	259,100.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,222,000.00	37,900,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	472,479,146.00	459,497,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	392,751,500.00	459,497,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	392,751,500.00	459,497,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,007,500.00	9,942,400.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	178,500.00	429,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,236,400.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	9,513,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,592,600.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	55,720,146.00	94,382,100.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	55,720,146.00	94,382,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	509,262,781.79	556,341,680.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	509,262,781.79	556,341,680.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	509,242,581.79	555,821,680.72

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	300,774,284.00	370,879,867.15
210101	Үндсэн цалин	300,774,284.00	207,694,700.00
210102	Нэмэгдэл	00.00	128,311,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	6,006,000.00
210104	Урамшуулал	00.00	31,154,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,047,713.00	46,435,131.00
210201	Тэтгэврийн даатгал	23,486,955.00	31,498,183.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,963,269.00	3,736,750.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,395,023.00	2,989,380.00
210204	Ажилгүйдлийн даатгал	612,635.00	737,348.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,589,831.00	7,473,470.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,889,175.00	9,301,145.00
210301	Гэрэл, цахилгаан	1,979,175.00	2,301,145.00
210302	Түлш, халаалт	10,910,000.00	7,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,067,640.00	32,811,850.00
210401	Бичиг хэрэг	3,212,350.00	4,332,050.00
210402	Тээвэр, шатахуун	29,049,790.00	25,311,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,430,500.00	2,504,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	375,000.00	664,000.00
2105	Нормативт зардал	53,195,388.44	71,480,323.31
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	39,434,888.44	53,725,273.31
210502	Хоол, хүнс	13,760,500.00	17,755,050.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,012,800.00	4,063,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,732,800.00	00.00
210604	Урсгал засвар	280,000.00	4,063,000.00
2107	Томилот, зочны зардал	1,371,000.00	559,500.00
210702	Дотоод албан томилот	1,371,000.00	559,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	494,840.00	656,168.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	92,860.00	102,160.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	59,580.00	108,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00
210807	Газрын төлбөр	22,400.00	20,608.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	24,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,389,741.35	19,634,696.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,999,700.00	944,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,390,041.35	18,690,196.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,200.00	520,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,200.00	520,000.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,200.00	520,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-34,302,535.79	45,380,719.28
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-34,302,535.79	45,380,719.28

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	472,738,246.00	563,822,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	259,100.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	259,100.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	259,100.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	259,100.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	472,479,146.00	563,822,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	392,751,500.00	459,497,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	392,751,500.00	459,497,900.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	00.00	1,971,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,007,500.00	9,942,400.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	178,500.00	429,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,236,400.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	9,513,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,592,600.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	55,720,146.00	94,382,100.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	55,720,146.00	94,382,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	472,738,246.00	563,822,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	472,738,246.00	563,822,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	472,218,246.00	557,570,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	294,021,300.00	373,166,500.00
210101	Үндсэн цалин	188,477,600.00	207,694,700.00
210102	Нэмэгдэл	78,439,900.00	128,311,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,006,000.00	6,006,000.00
210104	Урамшуулал	21,097,800.00	31,154,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,627,600.00	46,765,700.00
210201	Тэтгэврийн даатгал	25,586,800.00	32,909,200.00

210202	Тэтгэмжийн даатгал	3,010,200.00	3,464,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,408,200.00	2,771,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	602,000.00	692,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,020,400.00	6,928,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,814,175.00	11,126,645.00
210301	Гэрэл, цахилгаан	1,604,086.00	2,196,000.00
210302	Түлш, халаалт	10,210,089.00	8,825,500.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	105,145.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,331,249.00	30,003,150.00
210401	Бичиг хэрэг	703,000.00	845,750.00
210402	Тээвэр, шатахуун	29,531,849.00	22,933,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,430,500.00	2,504,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,665,900.00	1,720,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	2,000,000.00
2105	Нормативт зардал	61,825,182.00	80,336,437.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	44,549,876.00	63,837,652.00
210502	Хоол, хүнс	15,538,250.00	15,977,115.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,737,056.00	521,670.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,835,700.00	8,455,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	5,627,900.00
210602	Тавилга	3,000,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	331,300.00	333,000.00
210604	Урсгал засвар	6,504,400.00	2,495,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,371,000.00	559,500.00
210702	Дотоод албан томилолт	1,371,000.00	559,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	987,040.01	1,156,168.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	92,860.00	102,160.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	59,580.00	108,900.00
210807	Газрын төлбөр	22,400.00	20,608.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	24,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	492,200.01	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,405,000.00	6,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,405,000.00	6,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	520,000.00	6,252,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	520,000.00	520,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	520,000.00	520,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	5,732,400.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,732,400.00

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТ ИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	176,837,308.00	420,699,095.08	50,037,597.31	647,574,000.39
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	176,837,308.00	420,699,095.08	50,037,597.31	647,574,000.39
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	11,183,585.54	11,183,585.54
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	176,837,308.00	420,699,095.08	15,735,061.52	613,271,464.60
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	176,837,308.00	420,699,095.08	15,735,061.52	613,271,464.60
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	5,750,720.00	5,750,720.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	176,837,308.00	420,699,095.08	21,485,781.52	619,022,184.60
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-5,750,720.00	00.00	-5,750,720.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	45,380,719.28	45,380,719.28
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	176,837,308.00	414,948,375.08	66,866,500.80	658,652,183.88

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**Төгрөгөөр**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	558,497,900.00	553,880,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	558,497,900.00	553,880,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	557,977,900.00	553,360,000.00

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	373,166,500.00	373,166,500.00
210101	Үндсэн цалин	207,694,700.00	207,694,700.00
210102	Нэмэгдэл	128,311,600.00	128,311,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,006,000.00	6,006,000.00
210104	Урамшуулал	31,154,200.00	31,154,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,765,700.00	46,765,700.00
210201	Тэтгэврийн даатгал	32,909,200.00	32,909,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,464,100.00	3,464,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,771,300.00	2,771,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	692,800.00	692,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,928,300.00	6,928,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,156,500.00	11,126,645.00
210301	Гэрэл, цахилгаан	2,196,000.00	2,196,000.00
210302	Түлш, халаалт	8,825,500.00	8,825,500.00
210303	Цэвэр, бохир ус	135,000.00	105,145.00
210304	Байрны түрээс	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,823,100.00	29,928,150.00
210401	Бичиг хэрэг	1,010,000.00	845,750.00
210402	Тээвэр, шатахуун	22,933,100.00	22,933,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,880,000.00	2,429,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	1,720,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	2,000,000.00
2105	Нормативт зардал	78,151,100.00	76,201,437.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	59,711,100.00	59,627,652.00
210502	Хоол, хүнс	15,990,000.00	16,052,115.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,450,000.00	521,670.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,500,000.00	8,455,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	5,627,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	333,000.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	2,495,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,040,000.00	559,500.00
210702	Дотоод албан томилолт	1,040,000.00	559,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,375,000.00	1,156,168.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	102,160.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,000.00	108,900.00
210807	Газрын төлбөр	55,000.00	20,608.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	60,000.00	24,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	500,000.00	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6000000.00	6000000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	6,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	520000.00	520000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	520,000.00	520,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	520,000.00	520,000.00

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	558,497,900.00	553,880,000.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	459,497,900.00	459,497,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	459,497,900.00	459,497,900.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	99,000,000.00	94,382,100.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	99,000,000.00	94,382,100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27.00	27.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	20.00	20.00
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,942,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,942,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	914,000.00
2105	Нормативт зардал	914,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	914,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,028,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,028,400.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9942400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,942,400.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	429,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,217,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,296,000.00

3.АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Мөст сумын сум дундын эмнэлэг 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Эрхлэгч эмч Ж.Пүрэвбаатарт танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд байгууллагын дотоод хяналт хэрэгжүүлээгүй, авлага барагдуулаагүй, өглөгийг тооцоо хийж баталагаажуулаагүй, шилэн дансны мэдээллийн талаар менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дүгээр сарын 06-наас 2021 оны 03 дугаар сарын 10-ний хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Б.Бадамцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь Ковид -19 цар тахлын нөхцөл байдлын улмаас хорио цээр тогтоосон, нягтлан бодогчийн ажлын хариуцлага сул зэргээс хамаарч 2021 оны 3 дугаар сарын 06-ны өдөр хуулийн хугацаа хоцроож аудитад тайлангаа ирүүлсэн тул Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаа хоцорч тайланг баталгаажуулсан болно.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Ховд аймгийн Мөст сумын сум дундын эмнэлэг нь Нийгмийн эрүүл мэндийн тусламжийг чанартай хүртээмжтэй тусламжийг сумынхаа болон зэргэлдээх сумдын иргэдэд жигд хүртээмжтэй хүргэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл: 2008 оны 06 сарын 23-ны өдрийн 01 тоот тогтоолоор Ховд аймгийн Мөст сумын сум дундын эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт*
- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Мөст сумын сум дундын эмнэлгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдээгүй байна. Харин сумын санхүүгийн албанаас төрийн сангийн хяналтыг тухай бүр хэрэгжүүлсэн боловч төрийн сангийн хяналт сул хангалтгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 419429.8 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 4194,3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 601722.4 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 6017.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мөст сумын сум дундын эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 45345,8 мянган төгрөгөөр буюу 7.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
АВЛАГА	606.6	6339.0	5732.4
БАРАА МАТЕРИАЛ	70,874,3	85,977,9	15103,6
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	553,288,8	580,798,6	27,509,8
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	624,769,8	673,115,6	48345,8
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,498,3	14,463,4	2,965,1
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	613,271,5	658,652,2	45,380,7
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	624,769,8	667,383,2	45,345,8

Оны эхэнд байсан 606.6 мянган төгрөгийн авлага барагдаагүй байгаа нь хүмүүсээс тооцоо хийж суутгаагүй байна. Эрүүл мэндийн даатгалын төвлөрүүлсэн 5732,4 мянган төгрөгийн санхүүжилтийг буцаан авахаар авлагаар тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 85977.9 мянган төгрөг болж 15103.6 төгрөгөөр өссөн нь тайланд онд эм бэлдмэл нөөцөлсөнтэй холбоотой ба нярав нь эм эргэлтийн сангаа хамт хариуцаж 40 хувийн нэмэгдэл авч байгаа боловч эмний тооцоо нийлээгүй, ерийн үлдэгдэлтэй баталгаажуулаагүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 819826,2 мянган төгрөг, оны эцэст 812773,6 мянган төгрөг болж 46200,0 мянган төгрөгөөр өсөж 53252,6 мянган төгрөгийн хөрөнгө акталж өмнөх оны 5750,7 мянган төгрөгийн хөрөнгийн залруулга хийсэн байна.

Энэ нь тайлант онд үнэ төлбөргүй 37900.0 мянган төгрөгийн автомашин, 3300,0 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, 5000.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, худалдан авч нийт 46200.0 мянган төгрөгөөр нэмэгджээ.

Мөст сумын сум дундын эмнэлгийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 126762.2 мянган төгрөгөөр буюу 26.7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 126762.2 мянган төгрөгийн орлогоос 66746,4 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 41957,9 мянган төгрөгөөр, 35418,9 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй орлого нэмэгдсэн, нэмэлт санхүүжилтийн орлого 17361,1 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 52811.3 мянган төгрөг буюу 10.4 хувиар өссөн нь цалин, шимтгэлийн зардал 78493.0 мянган төгрөг буюу 45.3 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн 161,3 мянган төгрөг буюу 32.6 хувь, нормативд зардал нь 18284,9 мянган төгрөг буюу 34,4 хувь, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 499.8 мянган төгрөг буюу 247,0 хувиар өссөн, тогтмол зардал 3588.0 мянган төгрөг буюу 27,7 хувь, бараа үйлчилгээний бусад зардал 42755,0 мянган төгрөг буюу 94,1 хувь, хангамж бараа материалын зардал 2255,8 мянган төгрөг буюу 7.5 хувь, томилолт 811,5 төгрөг 59,2 хувь, эд хогшил 949.8 мянган төгрөг буюу 19,0 хувиар буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт.

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 459497.9 мянган төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг 99000.0 мянган төгрөг нийт 558497.9 мянган төгрөгөөр нийт зардлыг 558497.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлан онд улсын төсвөөс 459497.9 мянган төгрөгийн санхүүжилт, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 94,382,1 мянган төгрөгөөр нийт 553880,0 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс нийт 459497.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, эрүүл мэндийн санхүүжилт 94382,1 мянган төгрөг, нийт 553880,0 мянган төгрөг, эрүүл мэндийн санхүүжилт 4617,9 мянган төгрөгөөр дутуу санхүүжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 9942,4 мянган төгрөг төвлөрснөөс 914.0 мянган төгрөг эм бэлдмэлийн, 9028,4 мянган төгрөгийг бараа үйлчилгээний зардалд зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 150 мэдээллээс хугацаандаа оруулсан 145 мэдээлэл, хугацаандаа байршуулаагүй 5 мэдээлэл, дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан, Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэргийг 4 сарын мэдээллийг мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмж өгөгдсөнөөс зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 74692,4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 30332.1 мянган төгрөгийг залруулж, 2345.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 25159.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага, 16855,1 мянган төгрөгийн алдаа зөрчил давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа 30332,1 мянган төгрөгийн алдааг асуудлын бүртгэлээр танилцуулж, албан тоотой залруулга хийлээ.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар залруулагдаагүй 44360.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2345,2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 25159.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага бичиж хүргүүлээ.

1. Жолоочийн тооцоо бодоогүй, тооцооны хуудас бичигдээгүй, спидометрийн заалт баримтлаагүй шатахуун зарлагадсан, шатахуун олгох зөвшөөрлийн бичиггүй, эрхлэгч эмч нь өөрөө олгодог, шатахууны зарцуулалтад тавих хяналт сул, дотоод хяналт хэрэгжүүлээгүй, шатахууны өрүүсгэсэн 25159.9 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 6.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20-р зүйлийн 20.2.5 дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх,... тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 15-д "Хариуцаж байгаа эд зүйлийг зохих хууль ёсны баримт материал бүрдсэн буюу удирдлагын шийдвэрээр зориулагдсан зүйлд нь өөрийн биеэр тавьж олгож, хяналт тавьж ажиллана", Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 17-д "Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид өгч байна" гэсэн хуулийн заалтууд, "Үнэн зөв байдал", "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Анхан шатны баримтын бүрдэлгүй, тушаал шийдвэргүй үр дүнгийн урамшуулал, илүү цагийн мөнгө олгосон, нүүрсний үнэ төлсөн боловч орлого авч тайлагнаагүй, нүүрсний үлдэгдэл бодитоор байхгүй, хувь хүнээс бараа материал, хүнсний материал худалдан авахдаа ашгийн татвар тооцон суутгасан боловч төсөвт төвлөрүүлээгүй зэрэгтэй холбоотой 2345.2 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь *НББ-ийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.5-д " дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төсвийн тухай хуулийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" хуулийн заалтууд, "Үнэн зөв байдал", "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна*

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 16855.1 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.0. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар эмийн тооцоог нарийвчлан хянаж тооцох шаардлагатай байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Үндсэн хөрөнгө бэлтгэхтэй холбоотой асуудал

- 1.1 Илрүүлэлт: Тайлант онд холбогдох байгууллага, албан тушаалтны шийдвэргүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн, үнийн харьцуулалт хийгээгүйтэй холбоотой 8300,0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.4.хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох заалтуудыг, 24.4-д төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”, 41.2.3.”төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах, 20-р зүйлийн 20.2.5-д " дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2019 оны 06-р сарын 18-ны 271 тоот тогтоолын 3.1-д “ Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгийг эрх бүхий байгууллагаас баталсан төсөв, эдийн засгийн ангилал, зориулалтын дагуу болон Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу, үйлдвэрлэл, ажил үйлчилгээний үрдүнд бий болгох, эсхүл иргэн, хуулийн этгээдээс үнэ төлбөргүй шилжүүлж авах, түүнчлэн хандив, тусламж, бэлэглэл, эрх залгамжлах журмаар олж авна”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.1-д “Төрийн өмчид эд хөрөнгийг дараахь хэлбэрээр олж авна”, 3-д эрх бүхий байгууллагын шийдвэрээр худалдан авсан эд хөрөнгө, гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
- 1.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх, өндөр үнэтэй хөрөнгө бэлтгэх
- 1.3 Өгсөн зөвлөмж нь Холбогдох тушаал, шийдвэрийн дагуу батлагдсан төсвийн хүрээнд хөрөнгө бэлтгэх
- 1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Өглөгтэй холбоотой асуудал

- 2.1 Илрүүлэлт: Эмийн болон хүнсний тайлан гаргасан боловч тооцоо бодоогүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй, өглөгийн дүн батлагдахгүй 6629,9 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Нярав Ц.Золзаяа нь эм эргэлтийн санг хамтад нь хариуцан 40 хувийн нэмэгдэл авч ажиллаж байгаа нь хавсран гүйцэтгэх албан тушаалын ажил биш, хууль зөрчиж дотоод хяналтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20-р зүйлийн 20.2.5-д " дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх,...тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

- 2.2 Эрсдэл: Хөрөнгийн үр өгөөж буурах, хөрөнгө үрэгдэх, завших

2.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах, нярав, эм зүйчийн ажлыг салгах

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

3.Дотоод хяналттай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Байгууллагын дотоод хяналт хэрэгжээгүй, санхүүгийн ил тод мэдээлэл хангагдаагүй, эрхлэгч эмч нь ур чадварын нэмэгдлийг тушаал шийдвэргүй 12 сарын туршид авсан 1925.2 мянган төгрөгийн зөрчил, эмийн тооцоо бодолт хангалтгүй, түлш шатах тослох материал, эм, бараа материалын орлого, зарлагын зарцуулалтад дахин хяналт, шалгалт хийх шаардлагатай байна.

3.2 Эрсдэл: Дотоод хяналтын алба дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байх, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, завших, дутах, төсвийн үр өгөөж буурах

3.3 Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 311 дүгээр тогтоолын 1.5-д “энэ журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө”, 3.5-д “дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь хяналтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд 1 доошгүй удаа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ”, 3.6-д “дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ” гэсэн заалтуудыг мөрдөөгүй тул дотоод хяналтын баг томилон дээрх алдаа арилгуулан ажиллах

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4 Шилэн данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт: Шилэн дансны хуульд заасан дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан, Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага, холбогдох мэдээллийг мэдээлээгүй, 4-р сарын мэдээлэлийг байршуулаагүй байна.

4.2. Эрсдэл: Мэдээллийг ил тод нээлттэй мэдээлэхгүй байх, хуулийн заалтыг мөрдөөгүй байх

4.3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” мэдээлэх гэсэн заалтуудыг мөрдөн холбогдох мэдээллийг тухай бүрд мэдээлж хэвших.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо: 2021	Аудитын нэр: Мөст сумын сум дундын эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: ХОА-2021/2/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Мөст сумын сум дундын эмнэлэг	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант үеийн үр дүн зөрүүтэй илэрхийлсэн	29183,4	Залруулга		
2	Үндсэн үйл ажиллагааны санхүүжилтийн орлогыг алдаатай тайлагнасан	1148.7	Залруулга		
3	Жолоочийн тооцоо бодоогүй, тооцооны хуудас бичигдээгүй, спидометрийн заалт баримтлаагүй шатахуун зарлагдсан, шатахуун олгох зөвшөөрлийн бичгийг дарга нар олгодог, шатахууны зарцуулалтад тавих хяналт сул, дотоод хяналт хэрэгжүүлээгүй	25159.9	Албан шаардлага		
4	Анхан шатны баримтын бүрдэлгүй, тушаал шийдвэргүй үр дүнгийн урамшуулал, илүү цагийн мөнгө олгосон, нүүрсний үнэ төлсөн боловч орлого авч тайлагнаагүй, нүүрсний үлдэгдэл бодитоор байхгүй, шатахууны тайлан гаргаагүй, үрэлгэн зарцуулсан зарцуулалтыг тайлагнаагүй, олгосноо баталгаажуулаагүй, хувь хүнээс бараа материал, хүнсний материал худалдан авахдаа ашгийн татвар тооцон суутгасан боловч төсөвт төвлөрүүлээгүй зэрэгтэй холбоотой	2345.2	Төлбөрийн акт	Дарга Ня-бо	Ж.Пүрэвбаатар С.Ульянов
5	Байгууллагын дотоод хяналт хэрэгжээгүй, санхүүгийн ил тод мэдээлэл хангагдаагүй, эрхлэгч эмч нь үр чадварын нэмэгдлийг тушаал шийдвэргүй 12 сарын туршид авсан 1925.2 мянган төгрөгийн зөрчил, эмийн тооцоо бодолт хангалтгүй, түлш шатах тослох материал, эм, бараа материалын орлого, зарлагын зарцуулалтанд дахин хяналт, шалгалт хийх шаардлагатай байна.	1925.2	Зөвлөмж		
6	Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй	0	Зөвлөмж өгөх		

7	Тайлант онд зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн	8300.0	Зөвлөмж өгөх		
8	Эмийн болон хүнсний тайлан гаргасан боловч тооцоо бодоогүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй, өглөгийн дүн батлагдахгүй байна. Мөн нярав Ц.Золзаяа нь эм эргэлтийн санг хамтад нь хариуцан 40 хувийн нэмэгдэл авч ажиллаж байгаа нь хавсран гүйцэтгэх албан тушаалын ажил биш, зөрчил үүсэж байна.	6629.9	Зөвлөмж өгөх		
Дүн		74692.3			

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

Огноо: 2021. 03.10

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

Огноо: 2021. 03.10

БЭЛТГЭСЭН:

ГЭРЭЭТ АУДИТОР

Б.БАДАМЦЭЦЭГ

Огноо: 2021. 03.10